ТАВАН БОГД КАПИТАЛ
БОЛОМЖОО БОДИТ БОЛГО

# БАНКНЫ САЛБАРЫН ТОЙМ

## 2022 ОНЫ 8 ДУГААР САР

2022.09.30

# Банкуудын зээл олголт, багц

ТАВАН БОГД КАПИТАЛ
БОЛОМЖОО БОДИТ БОЛГО

**Нийт актив**
**₮40.2 их наяд**
**Нийт зээл**
**₮22.6 их наяд**
**Хадгаламж**
**₮18.5 их наяд**
**Харилцах**
**₮8.9 их наяд**
**Өөрийн хөрөнгө**
**₮4.4 их наяд**

## Банкны салбарын ерөнхий тойм

Монгол улсад нийт 12 арилжааны банк байдаг. Улаанбаатар хот болон орон нутагт нийт 1,385 салбар нэгж, 16,236 ажилтантайгаар үйл ажиллагаагаа явуулж байгаагаас Улаанбаатар хотод нийт 402 салбар нэгж, гадаадад 4 салбар байршиж байна. Арилжааны банкуудаас Хаан банк, Худалдаа хөгжлийн банк, Голомт банк, Төрийн банк болон Хас банк нь системийн нөлөө бүхий банк юм.

## 2022 оны 9 дүгээр сарын үйл явдал- Мөнгөний бодлогын мэдэгдэл

Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны 2022 оны 9 дугаар сарын 16, 20-ны өдрийн ээлжит хурлаар эдийн засаг, банк, санхүүгийн зах зээлийн өнөөгийн байдал гадаад, дотоод орчны төлөв, эрсдэлийг харгалзан үзээд:

1. Бодлогын хүүг 2 нэгж хувиар нэмэгдүүлж 12 хувьд хүргэх;
2. Бодлогын хүүний коридорыг бодлогын хүүнээс +2, -2 нэгж хувийн өргөнтэй болгох;
3. Банкуудын 360 хоног ба түүнээс дээш хугацаагаар гадаад зах зээлээс бонд болон зээл хэлбэрээр шинээр татсан эх үүсвэрийг заавал байлгах нөөц тооцох эх үүсвэрээс хасаж тооцох шийдвэргаргалаа.

## Банкуудын зээл олголт, зээлийн багц

» Тайлант сард банкуудын нийт зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үетэй харьцуулахад 14.6% өсөж, 22.6 их наяд төгрөг болсон байна. Тодруулбал өмнөх оны мөн үеэс хувийн байгууллагын зээл 18 хувиар өсч 10.5 их наяд төгрөгт, иргэдийн зээл 16 хувиар өсч 11.4 их наяд төгрөгт хүрчээ. Нийт зээлийн 1.4 их наяд төгрөг буюу 6.1% нь гадаад валютаар илэрхийлэгдсэн зээл, үлдсэн 93.9% нь төгрөгөөр олгогдсон зээл байна. Мөн зээлийн нийт үлдэгдлийн 47.5% нь хувийн байгууллага, 0.6% нь улсын байгууллага, 51.6% нь иргэдийн зээл, үлдсэн 0.2% нь бусад байгууллагуудад олгогдсон зээл байна.

» Тайлант сард шинээр олгосон зээл өмнөх сараас 394.4 тэрбум төгрөгөөр, эргэн төлөгдсөн зээл 230.2 тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна. Доорх зурагт 8 дугаар сард олгогдсон болон төлөгдсөн зээлийг өмнөх тайлант сартай харьцуулсан дэлгэрэнгүйг харуулав.

*Зураг 1: 2022 оны 7-р сард олгосон, төлөгдсөн зээл (тэрбум төгрөг)*




*Зураг 2: 2022 оны 8-р сард олгосон, төлөгдсөн зээл (тэрбум төгрөг)*

*Эх сурвалж: Монголбанк*

# Банкуудын зээл олголт, багц

2022 оны 8 дугаар сарын байдлаар нийт зээлийн багц 22.6 их наяд төгрөг байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.9 их наяд төгрөгөөр өсөж, өмнөх сартай харьцуулахад 550.4 тэрбум төгрөгөөр буурсан байгаа ба үүнээс хувийн байгууллагын зээлийн багцын үлдэгдэл 50 тэрбум төгрөгөөр буурч 10.5 их наяд, иргэдийн зээл 515.4 тэрбум төгрөгөөр буурч 11.4 их наяд болжээ.

Харин зээлийн багцын хувьд 21.04%-ийг бөөний болон жижиглэн худалдаа, 13.84%-ийг үл хөдлөх хөрөнгө, 8.24%-ийг барилга, 7.79%-ийг боловсруулах үйлдвэрлэл, 7.51%-ийг уул уурхай, салбарт олгосон байна. Энэ тус салбарууд зээлийн санхүүжилтийн хэлбэрийг илүүд үзэж үйл ажиллагаа явуулж байгааг харж болох ба өмнөх сарын зээл олголттой харьцуулахад үл хөдлөх хөрөнгийн салбарын зээл бага зэрэг бууралттай байгаа бол бусад салбарын зээлийн хувьд тогтмолын өөрчлөлт гараагүй байна.

Тайлант сард нийт хэвийн зээлийн дүн 18.8 их наяд төгрөг, үүний 59.1% нь 1-5 жилийн хугацаатай, 22.7% нь урт хугацаат зээлүүд байна. Мөн нийт зээлийн 5.3 хувь нь анхаарал хандуулах зээл, 11.1 хувь нь чанаргүй зээл байна. Чанаргүй зээл өмнөх сараас 394.3 тэрбум төгрөгөөр өсөж, 2.5 их наяд төгрөг болсон байна.

Чанаргүй зээлийг бүтцээр нь задалбал:
20.9% - уул уурхай
16.8% - боловсруулах салбар
14.3% - барилга
10.5% - худалдаа
7..2% - санхүү, даатгал
6.4% - цалин, тэтгэврийн зээл байна.
Мөн нийт чанаргүй зээлийн 11.4% нь гадаад валютын зээл байна.

*Зураг 3: Зээлийн бүтэц, салбараар*

*Зураг 4: Зээлийн чанарын ангилал*




*Зураг 5: Чанаргүй зээлийн бүтэц, салбараар*

*Эх сурвалж: Монголбанк*

# Зээлийн жигнэсэн дундаж хүү

## Зээлийн жигнэсэн дундаж хүү

2022 оны 8-р сарын нийт зээлийн үлдэгдлээр тооцсон төгрөгийн зээлийн жигнэсэн дундаж хүү өмнөх оны мөн үеэс 0.5 нэгж хувиар буурч 15.4%, валютын хүү 0.6 нэгж хувиар өсөж 9.8% болсон байна. Энэ нь валютын ханшийн өсөлтийн нөлөөлөл бөгөөд төгрөг ам. долларын эсрэг сулрахын хэрээр төгрөгийн дундаж хүү буурч, валютын хүү өсөж байгаа билээ.

Харин шинээр олгосон төгрөгийн зээлийн хүү өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.3 нэгж хувиар өсөж 14.7% байгаа бол валютын зээлийн хүү өмнөх оны мөн үеэс 0.7 нэгж хувиар буурч 7.7% байна.

Тайлант хугацаанд шинээр олгосон зээл, шинээр татсан нийт хадгаламжийн хүүгийн зөрүү 5.6 нэгж хувь гарсан ба өмнөх оны мөн үед уг зөрүү 1.35 нэгж хувиар буурч байсан юм. Харин шинээр татсан хугацаатай хадгаламжийн дундаж хүүтэй харьцуулбал зөрүү 5.4% юм.

Тус сар иргэдэд олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү 15.1% байхад хувийн байгууллагуудад олгосон зээлийн хүү 14.6% байна.

Харин иргэдийн төгрөгийн зээлийн үлдэгдлийн ЖДХ 15.8 хувь, гадаад валютынх 14.2 хувь байна. Хувийн байгууллагын төгрөгийн зээлийн үлдэгдлийн ЖДХ 14.8 хувь, гадаад валютынх 9.7 хувь байна. Үлдэгдэлд болон олгосон зээлд тооцсон хүүгийн хувьд иргэдийн зээлийн хүү байгууллагын зээлийн хүүнээс илүү байгаа юм.

*Зураг 6: Шинээр олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү*




*Зураг 7: Шинээр олгосон зээл, хадгаламжийн хүүгийн зөрүү*




*Зураг 8: Шинээр олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү, салбараар*




*Эх сурвалж: Монголбанк*

# Банкуудын харилцах, хадгаламж, ипотекийн зээл

ТАВАН БОГД КАПИТАЛ
БОЛОМЖОО БОДИТ БОЛГО

**Нийт актив**
**₮40.2 их наяд**
**Нийт зээл**
**₮22.6 их наяд**
**Хадгаламж**
**₮17.3 их наяд**
**Харилцах**
**₮8.9 их наяд**
**Өөрийн хөрөнгө**
**₮4.4 их наяд**

## Банкуудын харилцах, хадгаламж

2022 оны 8-р сарын байдлаар нийт хадгаламж өмнөх оны мөн үеэс 11%-аар буурч, харилцахын үлдэгдэл 24%-аар өссөн байна. Үүнээс, төгрөгийн хадгаламж 16%-аар буурч, гадаад валютаар илэрхийлэгдэх хадгаламжийн хэмжээ 7%-аар өссөн байна. Энэ нь иргэд, аж ахуйн нэгжүүд мөнгөө төгрөгөөр хадгалах сонирхол буурч байгааг илтгэж байна. Мөн валютын харилцах хамгийн өндөр хувиар буюу 59% өсөлт үзүүлжээ.

Тайлант сард шинээр татсан төгрөгийн хадгаламжийн жигнэсэн дундаж хүү (ЖДХ) 9.18%, гадаад валютын хадгаламжийн ЖДХ 2.32% байна. Төгрөгийн хадгаламжийн ЖДХ өмнөх сараас 0.9 нэгж хувиар, өмнөх оны мөн үеэс 1.63 нэгж хувиар тус тус өссөн байна. Түүнчлэн валютын хадгаламжийн ЖДХ өмнөх сараас 0.5 нэгж хувиар буурч, өмнөх оны мөн үеэс 0.2 нэгж хувиар өссөн байдалтай байна. Зураг 9-д шинээр татсан хугацаатай хадгаламжийн хүүг харуулав.

*Зураг 9: *Хадгаламжийн хүү*




*Тайлбар: Шинээр татсан нийт хадгаламж болон хугацаатай хадгаламжийн хүү хоорондоо ялгаатайг анхаарна уу.

## Ипотекийн зээл олголт

2022 оны 8-р сард нийт 1,070 иргэнд нийт 112.5 тэрбум төгрөгийн зээлийг шинээр олгосон бөгөөд сарын эцсийн байдлаар нийт 106,323 зээлдэгчийн 6.11 их наяд төгрөгийн ипотекийн зээл байна. Сарын турш нийт 112.5 тэрбум төгрөгийн шинэ зээл олгогдож, 43.8 тэрбум төгрөгийн зээлийн эргэн төлөлт хийгджээ.

Тухайн сард олгосон ипотекийн зээлийн жигнэсэн дундаж хүү 8.32% хувьд хүрч, өмнөх оны мөн үеэс 0.5 нэгж хувиар өсч, өмнөх сараас 0.3 нэгжээр буурав.

Тайланд сард нийт 149.1 тэрбум төгрөг хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн ангилалд байна. Хугацаа хэтэрсэн болон чанаргүй ангилалтай зээлийн задаргааг Зураг 11-т дэлгэрэнгүй харуулав.

*Зураг 10:* Хугацаа хэтэрсэн болон чанаргүйд ангилагдсан ипотекийн зээлийн багц /тэрбум.төг/

*Эх сурвалж: Монголбанк*

# Макро эдийн засгийн орчин

ТАВАН БОГД КАПИТАЛ
БОЛОМЖОО БОДИТ БОЛГО

## Макро эдийн засгийн орчин

### Гадаад худалдааны тэнцэл:

2022 оны эхний 8 сарын гүйцэтгэлээр гадаад худалдааны нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 3,255 сая ам.долларoор өсөж 13,356 сая ам.долларт хүрсэн байна. Үүнд экспорт 38%-аар буюу 2,129 сая ам.долларoор, импорт 25%-аар буюу 1,126 сая ам.долларoор өссөн нь нөлөөлөв. Тайлант хугацаанд худалдааны тэнцлийн ашиг өнгөрсөн оны мөн үеэс 1,003 сая ам.долларoор өсөж 2,156 сая ам.долларын ашигтай гарлаа.

### Экспорт: 5.3 тэрбум ам.доллар (38%↑)

2022 оны эхний 8 сарын гүйцэтгэлээр өнгөрсөн оны мөн үеэс 38%-аар буюу 2,129 сая ам.долларoор өсөж 7,756 сая ам.долларт хүрчээ. Экспорт нийт 38 хувиар өсөхөд 39 нэгж хувийг уул уурхайн бүтээгдэхүүний өсөлт бүрдүүлсэн байна.

### Импорт: 3.9 тэрбум ам.доллар (25%↑)

2022 оны эхний 8 сарын гүйцэтгэлээр өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 25%-аар буюу 1,126 сая ам.долларoор өсөж 5,600 сая ам.долларт хүрчээ. Импорт 25 хувиар өсөхөд хэрэглээний бүтээгдэхүүний импорт 10 нэгж хувиар, нефтийн бүтээгдэхүүний импорт 9 нэгж хувиар, хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний импорт 4 нэгж хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлөв.

### Инфляц, бодлогын хүү:

Улсын инфляц 2022 оны 8 дугаар сарын байдлаар -0.9 хувь, жилийн инфляц 14.4 хувь байна. Улаанбаатар хотын хэмжээнд 14.8% гарав. Барааны бүлгээр авч үзвэл 10 нэгж хувийг хүнснээс бусад бараа, 4.8 нэгж хувийг хүнсний бараа бүрдүүлж байна. Хүнсний бүлгийн үнийн өсөлтөд талх, гурил, будаа болон хүнсний ногоо, сүү, сүүн бүтээгдэхүүний үнэ, хүнснээс бусад барааны үнийн өсөлтөд эм тариа болон шатахууны үнэ голлон нөлөөлжээ.

### Гадаад валютын ханш, албан нөөц:

Төгрөгийн ам.доллартой харьцах ханш сарын эцсийн байдлаар 3199.28 төгрөгт хүрсэн нь өмнөх сарын эцсээс 1.0 хувиар, өмнөх оны мөн үеэс 12.3 хувиар суларсан үзүүлэлт байна. Тайлант сарын дундаж ханш нь 3185.72 төгрөг байв

Харин төгрөгийн юаньтай харьцах сарын эцсийн ханш өмнөх сараас 1.7 хувиар чангарч, өмнөх оны мөн үеэс 4.9 хувиар суларч 462.78 төгрөгт хүрэв. Тухайн сарын хамгийн бага ханш нь 462.09 төгрөг байсан бол хамгийн өндөр ханш нь 472.68 төгрөг байлаа.

*Зураг 11: Төгрөг ам.долларын эрэлт (сарын хөдөлгөөнөөр)*




*Зураг 12: Төгрөг юанийн эрэлт (сарын хөдөлгөөнөөр)*




*Эх сурвалж: Монголбанк*

# АНДЕРРАЙТЕРИЙН ХЭЛТЭС

Банк Реформер, IPO, Бонд, Хувьцаа

ТАВАН БОГД КАПИТАЛ
БОЛОМЖОО БОДИТ БОЛГО

**С.ТҮВШИНЗАЯА**
*Андеррайтер хариуцсан дэд захирал*
tuvshinzaya@tavanbogdcapital.com

**Б.МЯГМАРСҮРЭН**
*Шинжээч*
myagmarsuren.b@tavanbogdcapital.com

**Э.АРИУНЗАЯА**
*Шинжээч*
ariunzaya.e@tavanbogdcapital.com

**Б.ГАН-ЭРДЭНЭ**
*Хуулийн зөвлөх*
ganerdene.b@tavanbogdcapital.com



**Бондын брокер: Б.Отгон**
9502-9966

**Хувьцааны брокер: Н.Мөнхчимэг**
9502-4664

tavanbogdcapital.com
cr@tavanbogdcapital.com